

АВТО ЗАМЫН ГАЗРЫН ДАРГА, МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН, МОНГОЛЫН АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРҮҮДИЙН
НИЙГЭМЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны 04 дугаар
сарын 17-ны өдөр

№ А/25/11/05

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны “Дүрэм батлах тухай” 196 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

- “Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд техникийн хяналт гүйцэтгэх инженерүүдэд итгэмжлэл олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Итгэмжлэл”-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Авто замын газрын дарга, Монголын авто замын инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2003 оны 22 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын газрын орлогч дарга, “Авто замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл” /Р.Онон/, Авто замын газрын Захиргаа, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Уганбаатар/-т даалгасугай.

АВТО ЗАМЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЭНХТӨР

МОНГОЛЫН АВТО
ЗАМЧДЫН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН

Т.БЯМБАА

АВТО ЗАМЧДЫН
ИМПОРТ

ТТГ 4014 № 1083872

МОНГОЛЫН АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРҮҮДИЙН
НИЙГЭМЛЭГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л.ГОМБО

Л.ГОМБО

Авто замын газрын дарга, Монголын авто замчдын холбооны тэргүүн, Монголын авто замын инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын 2012 оны 4 дүгээр сарын 123-ны 1083872 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖИЛД
ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ГҮЙЦЭТГЭХ ИНЖЕНЕРҮҮДЭД
ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд тавих мэргэжлийн хяналтыг сайжруулах, зөвлөх этгээдийн ажилтнуудыг чадваржуулах, мэргэшүүлэх, шаардлага хангасан хяналтын инженер техникийн ажилтан бэлтгэх, итгэмжлэл олгох, итгэмжлэгдсэн инженерүүдийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог бий болгоход энэхүү журамын зорилго оршино.

1.2. Энэ журам нь Монгол Улсын нутаг дээр гадаадын зээл тусlamж, улс, орон нутгийн төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, өргөтгөл, шинэтгэлийн ажилд /цаашид төсөл гэнэ/ техникийн хяналт тавих зөвлөх этгээдийн хяналтын инженер болон захиалагчийн инженерүүдэд итгэмжлэл олгоход хамаарна.

1.3. Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд техникийн хяналт тавих итгэмжлэл авсан ИТА нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж байгаа авто зам, гүүрийн барилга, засварын ажлын Зөвлөх үйлчилгээний техникийн хяналт, захиалагчийн хяналт, гүйцэтгэгч байгууллагын хурээнд зам, гүүрийн барилга засварын ажилд дотоодын чанарын хяналт тавих эрхтэй байна.

ХОЁР. Сургалт зохион байгуулах, итгэмжлэл олгох

2.1. Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд техникийн хяналт тавих ИТА-ныг тусгай программын дагуу сургалтанд хамруулж, шалгалт авч, итгэмжлэл олгоно.

2.2. Итгэмжлэл олгох сургалтыг Монголын авто замчдын холбооны сургалтын алба зохион байгуулна.

2.3. Итгэмжлэл олгох сургалтын хөтөлбөрийг Монголын авто замчдын холбооны сургалтын алба боловсруулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто замын газрын дарга, Монголын авто замчдын холбооны тэргүүн, Монголын авто замын инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирлаар батлуулна.

2.4. Инженерүүдээс шалгалт авах комиссыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто замын газрын дарга, Монголын авто замчдын холбооны тэргүүн, Монголын авто замын инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар томилно.

2.5. Шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто замын газрын дарга, Монголын авто замчдын холбооны тэргүүн,

Монголын авто замын инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар итгэмжлэлийг олгоно.

2.6. Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх итгэмжлэлийг дараах зэрэглэлээр олгоно.

- 2.6.1. Тэргүүн инженер /Chief Engineer/
- 2.6.2. Ахлах инженер /Senior Engineer/
- 2.6.3. Инженер /Engineer /
- 2.6.4. Туслах инженер /Junior engineer /

2.7. Авто зам, гүүрийн барилга, засварын ажлын геодезийн хэмжилт, материалын хяналт болон ажлын тоо хэмжээнд хяналт тавих итгэмжлэлийг дараах зэрэглэлээр олгоно.

- 2.7.1. Ахлах инженер /Senior Engineer/
- 2.7.2. Инженер /Engineer /
- 2.7.3. Туслах инженер /Junior engineer /

2.8. Хяналт хийх итгэмжлэлийг эхний удаа 2 жилийн хугацаатай олгох бөгөөд, давтан сургалтанд хамрагдсанаар 3 жилийн хугацаатайгаар 2 удаа сунгаж, 3 дахь удаагаас хугацаагүй сунгана.

2.9. Инженерийн зэрэглэл олгогдох хяналтын инженерүүд нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:

2.9.1. Тэргүүн инженер /Chief Engineer/ нь инженерийн магистр, эсвэл эрдмийн цол зэрэгтэй байхын зэрэгцээ зөвлөх, эсвэл мэргэшсэн инженерийн зэрэгтэй, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан байна.

2.9.2. Ахлах инженер /Senior Engineer/ нь инженерийн бакалавраас дээш цол зэрэгтэй байхын зэрэгцээ зөвлөх, эсвэл мэргэшсэн инженерийн зэрэгтэй, мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байна.

2.9.3. Инженер /Engineer/ нь инженерийн бакалавр зэрэгтэй байхын зэрэгцээ "Хяналтын инженерт итгэмжлэл олгох" сургалтад 2-оос доошгүй удаа хамрагдаж, шалгалт өгч тэнцсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байна.

2.9.4. Туслах инженер /Junior engineer/ нь инженерийн бакалавраас дээш зэрэгтэй эсвэл мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан авто замын дипломын инженер болон авто замын техникийн байхын зэрэгцээ хяналтын инженерийн сургалтад хамрагдан зохих шалгалт өгч, итгэмжлэл авсан байна.

2.10. Авто зам, гүүрийн Зөвлөх инженерийг сургалтанд хамруулж, шалгалт авахгүйгээр "Тэргүүн инженер"-ийн зэргийг шууд олгоно.

2.11. Хяналтын инженерийн сургалтад хамрагдан итгэмжлэл авсан инженер нь дараах ажлуудыг хийх боломжтой

2.11.1. Тэргүүн инженер /Chief Engineer/ нь хяналтын зөвлөх багийн ахлагч, ахлагчийн орлогч, хэсгийн ахлагч, голлох мэргэжилтэн

2.11.2. Ахлах инженер нь хяналтын багийн ахлагчийн орлогч, хэсгийн ахлагч, голлох мэргэжилтэн

2.11.3. Инженер нь хяналтын зөвлөх багийн голлох мэргэжилтэн, туслах мэргэжилтэн

2.11.4. Туслах инженер нь зөвхөн хяналтын зөвлөх багийн туслах мэргэжилтэн
ГУРАВ. Сургалтанд хамрагдагсадад тавигдах шаардлага, бүртгэх, бүрдүүлэх баримт бичиг

3.1. Хяналтын инженерийн итгэмжлэл олгох сургалтанд хамрагдагсадыг Монголын авто замчдын холбооны сургалтын алба бүртгэнэ.

3.2. Итгэмжлэл горилогч инженер нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

3.2.1. Тухайн горилогчийн сургалтанд хамрагдахыг хүссэн өргөдөл

3.2.2. Горилогчийн их, дээд сургууль, коллеж төгссөн дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан/

3.2.3. Хийсэн ажлын тайлан, ажлын газрын тодорхойлолт

3.2.4. Иргэний үнэмлэхийн хуулбар

3.2.5. Мэргэжил дээшлүүлсэн, гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан бол баталгаажих баримтын хуулбар /нотариатаар баталгаажуулсан/.

3.3. Итгэмжлэл олгох сургалтанд дараах болзлыг хангасан инженер хамрагдана.

3.3.1. Авто замын барилгын баклавраас дээш зэрэгтэй инженер

3.3.2. Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан авто замын дипломын инженер болон авто замын техник

3.3.3. Авто замын хэмжилтийн болон материалын хяналтын чиглэлээр авто замын инженерээс гадна авто замын салбарт 2-оос дээш жил ажилласан геодезийн болон барилгын материалын инженер

3.3.4. Ажлын тоо хэмжээнд хяналт тавих чиглэлээр авто замын инженерээс гадна инженер-эдийн засагч, программ хангамжийн инженер

3.4. Хяналт гүйцэтгэх итгэмжлэл авсан инженер нь өндөр ёс суртахуунтай байж, холбогдох хууль дүрэм, журмыг баримтлан хяналтын инженерийн нэр хүндийг байнга эрхэмлэнэ.

ДӨРӨВ. Шалгалт авах

4.1. Сургалтанд хамрагдагсадаас авах шалгалтыг энэ журамд заагдсан шалгалтын комисс авна. Шалгалтын товийг шалгалтын комисс тогтооно.

4.2. Шалгалтыг тестын журмаар, 100 баллын системээр авна. Шалгалтанд 80 ба түүнээс дээш оноо авсан хүнийг шаардлага хангасан гэж үзнэ.

4.3. Шалгалтанд 80 онооноос доош оноо авсан ИТА-ныг 1 удаа дахин шалгалтанд оруулах ба дахин 80-аас доош оноо авбал дараа жил сургалтанд хамруулж шалгалт авна. Дахин шалгалтанд орохын тулд сургалтын төлбөрийн 30%-тай тэнцэх хэмжээний төлбөр төлнө.

ТАВ.Шалгалтын комиссын эрх, үүрэг

5.1. Шалгалтын комиссын гишүүд нь шалгалтанд орж байгаа инженерүүдийг нас, хүйс болон энэ журамд заасан ажил мэргэжлээр ялгаравлахгүй байна

5.2. Шалгалтын комисс нь нийт сургалтанд хамрагсадын ирцийн бүртгэл, энэхүү журамд заасан ажил мэргэжлийн байдал, ажлын газрын тодорхойлолт зэргийг нарийвчлан шалган үзэх үүрэгтэй.

5.3. Шалгалтын комисс нь энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангагүй хүмүүсээс шалгалт авахгүй байх эрхтэй.

5.4. Шалгалтын комисс нь шалгалт авах тестийг боловсруулан шалгалтыг авна. Шалгалтын тестэд тухайн хичээлийг заасан багшийн саналыг авч тусгана.

5.5. Шалгалтын комиссын гишүүд нь шалгалтын материалыг үнэн зөв, шударга, алдаа гаргахгүй дүгнэх үүрэгтэй.

ЗУРГАА. Төлбөр, тайлан

6.1. Итгэмжлэл олгох сургалтанд хамрагдагсад нь сургалтын төлбөр төлнө.

6.2. Сургалтын төлбөрийг Монголын авто замчдын холбооны сургалтын алба хураан авч сургалт зохион байгуулах байр, техник хэрэгслэл, багш нарын хөдөлмөрийн хэлс, сертификатын үнэ болон бусад зүйлд зарцуулна.

6.3. Сургалтын төлбөрийн зарцуулалтын тайланг зохих журмын дагуу гаргаж "Авто замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл"-ийн даргад танилцуулна.

6.4. Сургалтын төлбөрийн тайланг Монголын авто замчдын холбооны нэгдсэн тайлан баланст тусгана.

ДОЛОО. Хяналтын инженерүүдийн бүртгэл мэдээллийн сан

7.1. Хяналт тавих итгэмжлэл олгосон ИТА-үүдийн бүртгэл, мэдээллийн сан нь Авто замын газрын Захиргаа, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Монголын авто замчдын холбооны архивт хадгалагдана.

7.2. Бүртгэл мэдээллийн санд оруулах өөрчлөлтийг Монголын авто замчдын холбооны сургалтын албаны тайланг үндэслэн жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Авто замын газрын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн, Монголын авто замчдын холбооны сургалтын менежер нар хийж, нийтэд мэдээлнэ.

7.3. Хяналт тавих итгэмжлэл олгосон ИТА-ны бүртгэл, мэдээллийн санг Авто замын газар, Монголын авто замчдын холбоо, Авто замын инженерүүдийн нийгэмлэгийн цахим хуудсанд байрлуулж нийтэд ил тод болгоно.

7.4. Хяналтын инженерүүдийн бүртгэл мэдээллийн сан нь дараах үндсэн мэдээллийг агуулсан байна.

- 7.4.1. Инженерийн овог, нэр
- 7.4.2. Нас, хүйс
- 7.4.3. Төгссөн их дээд сургууль
- 7.4.4. Хэлний боловсрол
- 7.4.5. Мэргэжил ба цол, зэрэг
- 7.4.6. Инженерийн зэрэглэл
- 7.4.7. Мэргэжлээрээ ажилласан хугацаа
- 7.4.8. Ажлын туршлага
- 7.4.9. Ажилладаг байгууллага

НАЙМ. Хяналт хийх итгэмжлэлийг хүчингүй болгох

8.1. Хяналт хийх итгэмжлэлыг дараах нөхцөлд хүчингүй болгоно.

8.1.1.Хяналтын ажилд удаа дараа хариуцлагагүй хандаж, энэ талаараа захиргааны арга хэмжээ шат дараалан авагдсан

8.1.2.Авилга авсан болон авахаар завдсан нь хууль хяналтын байгууллагуудаар тогтоогдсон

8.1.3.Мэргэжлийн алдаа гаргаснаас захиалагч болон бусдад их хэмжээний хохирол учруулсан нь холбогдох хяналтын болон мэргэжлийн байгууллагуудаар тогтоогдсон.

8.2. Хяналт хийх итгэмжлэлийг хүчингүй болгох асуудлыг Авто замын газрын дарга, Монголын авто замчдын холбооны тэргүүн, Монголын авто замын инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар шийдвэрлэнэ.

8.3. Хяналт хийх итгэмжлэлийг хүчингүй болгосноор тухайн инженер нь 2 жилийн хугацаанд хяналтын инженерээр ажиллах эрхгүй.

8.4. Итгэмжлэл нь хүчингүй болсон, хугацаа нь дууссан инженерүүд дахин эрх авахыг хүсвэл энэхүү журамд заасны дагуу материалыг бүрдүүлж, сургалтанд хамрагдана.